



ХАРЬЯА АГЕНТЛАГ,
БАЙГУУЛЛАГУУДАД

МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЫН САЙД

15100 Увсэнбаатар хот, Нингэнсай суурал,
Төвдөр хорооний гудамж 5, Утас: 39-15-53
Факс: 32-26-34 Цахим хуудас: <http://gmn.mn>
Цахим хуудас: www.ceb.gov.mn

2019.08.19 № 11789
талбай _____ анги № _____

Чиглэл өгөх тухай

Хөдөлмөр, нийгмийн хамгаалын салбарын 2019 оны Удирдах ажилтны зөвлөгөөнөөс харьяа агентлаг, байгууллагуудын удирдлагуудад чиглэл хүргүүлж байна. Энэхүү чиглэлийг хэрэгжүүлж ажиллахад дараах асуудалд онцгойлон анхаарч ажиллахыг үүрэг болгож байна. Үүнд:

1. Цахим мэдээллийн суурь бүтцэд суурилан мэдээллийн нэгдсэн сангийн хадгалалт, хамгаалалт, цахим сүлжээний хэвийн ажиллагааг хангаж, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд нээлттэй, хүртээмжтэй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг авахад иргэдээс авдаг цаасан нотлох баримтыг бүрэн цахимжуулж, цахим хэрэглээг нэмэгдүүлэх,

2. Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг "Хариуцлагын жил" болгон зарласантай холбогдуулан, 2019 онд сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж, арга хэмжээ авч, ахиц дэвшил гаргаж ажиллахыг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэх,

3. Төрийн албаны /шинэчилсэн найруулга/ тухай, Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шударга, тэгш зарчим баримтлан ажиллах, төрийн албан хаагчдыг тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжаа аваад ажиллаж байгаа хүмүүсийг өндөр насны тэтгэвэрт суулгах, "Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам"-д өөрчлөлт оруулах санал боловсруулж хэрэгжүүлэх,

4. Салбарын бүх шатанд төсвийг үр ашигтай, зөв зохистой зарцуулах, ер төлбөр үүсгэхгүй байх, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах, үр дүнг тооцох, Төсвийн тухай хуулийг мөрдөж, төсвийн сахилга батыг чанд сахиж ажиллах,

5. Засгийн газрын тусгай сангуудын зарцуулалт үр дүн, хэрэгжилтэд онцгой анхаарч, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлдэг хөтөлбөр, төслийг илүү боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохион байгуулах, эрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох арга, аргачлалыг шинэчлэн сайжруулах,

6. Төсвийн төсөл, Улсын хэмжээнд хэрэгжих томоохон төсөл, хөтөлбөрийн үндэслэл, тооцоо судалгааг үнэн зөв бодитой төлөвлөж, тайлбар үндэслэлийг сайтар гарган, улсын төсөвт бүрэн туслуулахад анхаарах,

7. Хүүхдийн хөгжил, хамгааллын зардалд батлагдсан 7.9 тэрбум төгрөгийг үр дүнтэй зориулалтын дагуу зарцуулж, хүчирхийлэлд өртсөн болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үйлчилгээг цаг алдалгүй хүргэж, хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулахад анхаарч ажиллах;

8. Хүүхдийн тусламжийн 109 утасны төв, Хохирогчийг хамгаалах Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйл ажиллагааг сайжруулж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах,

9. "Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 2019 оны Засгийн газрын 57 дугаар тогтоелыг хэрэгжүүлэх, Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, санал боловсруулан танилцуулах,

10. Төрийн албаны /шинэчилсэн найруулга/ тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг чирэгдэлгүй шуурхай шийдвэрлэх,

11. Дээрх чиглэлийг 2019 оны 03 дугаар сард багтаан салбарын удирдах ажилтны зөвлөгөөнөөр хэлэлцэж, орок нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зэрэг болно.

САЙД  С.ЧИНЗОРИГ

